

Лекц №12

Багаараа Бүтээлч Сэтгэлгээгээ Хөгжүүлцгээ! (Гэр бүлийн багийн жишээгээр)

Агуулга

1. Өнөөгийн амьдралын хэв маягаа эрэгцүүлэн тунгаахуй,
2. Бүтээлч сэтгэлгээ хөгжүүлэх орчин, түүнд суралцах багийн хамтын ажиллагаа
3. Хичээлээр хийгдэх ажлууд
4. Даалгавар

1. ӨНӨӨГИЙН АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГАА ЭРЭГЦҮҮЛЭН ТУНГААХУЙ

Өнөөдөр бидний “онлайн”, “офлайн” гэж гадаад үгээр хэлж, ойлгоод байгаа зүйл маань бүрэн гйүцэд ойлгож амжаагүй шахам байхад л “онлайн” нь “офлайн”-аа үерийн ус мэт түрэн орж ирлээ.

Нийгмийн бүх салбарт дижитал технологи хүссэн хүсээгүй “хүзүү ороон” хүрч ирлээ. Энэ үзэгдэл бодитой бөгөөд маргаангүй юм. Тэртэй тэргүй хямарч байсан зүйлийг хижиг тахлын хөл хорио бүр хурдасгаад, хурдасгахаар барахгүй хуйлруулаад хаячихлаа.

Ингээд бодит “амьд” харилцааны хил хязгаар хумигдсан ийм үед виртуаль буюу материаллаг бус ертөнцийн хил хязгаар тэлж холбоо харилцааны технологийн ололтоор зуучлуулан урлаг соёл, боловсролын үйлчилгээг хүмүүс гэр орондоо, ажлынхаа байран дээр авах боллоо.

Аливаа зүйл хоёр талтаай байдаг хойно доо. Өнөөгийн энэ үзэгдэл, үйл явц ч бас л хоёр талтай. Бүтээлч сэтгэлгээгээ хөгжүүлэх тал дээр анхаарлаа хандуулж буй бидний хувьд хямралыг боломж болгох бүтээлч хандлага ч бас байж болмоор санагдаж байна. Өөрөөр хэлбэл, хөл хорио нь нийгэм, боловсрол, соёлын харилцааг хязгаарласан тул өөртөө, гэр бүлдээ зариулах зөндөө цаг гараад ирсэн хэрэг. Өөрчлөлтөнд бэлэн хүмүүст бөөн “цагийн олз”. Дээрээс нь цахимаар гэртээ байж байгаад ханьгайгаа, хүүхдүүдтэйгээ хамтдаа бүхнийг хийх боломж байна. Бид өөрсдийгөө өөрчлөлтөнд бэлэн хүмүүст тооцох хэрэгтэй. Учрыг нь бүхэн өөрсдөө мэдэж байгаа....

Заримдаа манай ард түмний ярьж заншсанаар “Ардын сурган хүмүүжүүлэхзүй” гэдэг үнэт өв маань бүтээлч сэтгэлгээгээ хүүхдүүдтэйгээ, гэр бүлээрээ, хамтдаа багаараа хөгжүүлэх гол арга болох юм биш үү гэсэн бодолд хүргэж байна. Тиймээс энэ удаагийн хичээлийг энэ тал руу нь чиглүүллээ. Ер нь ч тэгээд гэр бүлийн хүмүүжил, боловсрол гэдэг тухайн хүний амьдралдаа мөрддөг гол зарчим болдог. Тиймээс хүний

багаар ажиллах сэтгэлгээ төлөвшүүлэх, багаараа бүтээлч сэтгэлгээгээ хөгжүүлэх энэ бүхний эхлэл гэр бүлээс эхэй гэж үзэж болох юм. Иймээс гэр бүлийн багаас эхэлье.

2. БҮТЭЭЛЧ СЭТГЭЛГЭЭ ХӨГЖҮҮЛЭХ ОРЧИН, ТҮҮНД СУРАЛЦАХ БАГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Хүүхдүүд бол бидний хувьд ТРИЗ-ийн багш нар

Яагаад?

Яг эндээс, “Яагаад”-аас Бүтээлч Сэтгэлгээ эхэлнэ. Яагаад? Гэсэн асуулт байхгүй бол сэтгэлгээ бүтээлч бус байна гэсэн үг. Бүтээлч бус сэтгэлгээтэй хүмүүс заасныг тогтоочихоод л, хий гэснийг хийчхээд л, өгснийг авчихаад л “хорвоогийн тоос” хөдөлгөөд явж байдаг. Ямар ч байсан тэдний гараас, тэдний толгойноос шинэ юм гарахгүй.

Хүн бүрийн ухамсар, уураг тархи бүтээлч чанартай. Сэтгэлгээний бүтээлч чанарыг идэвхжүүлж, хөгжүүлж болдог. Өөрөөр хэлбэл, Бүтээлч Сэтгэлгээнд сургаж, суралцаж болдог гэдгийг бид хичээл болгоны жишээнээс ойлгож байгаа.

Хамгийн Бүтээлч Сэтгэлгээтэй хүмүүс хэн бэ? Суут ухаантан, сод авьяастнууд уу?

Хамгийн Бүтээлч Сэтгэлгээтэй хүмүүс бол ХҮҮХДҮҮД. Тийм ээ, хөлд тээглээд л, хамаг гэр орон буулгаад л, ажил хийлгэхгүй асуултаудаараа булаад л, “зүгээр бай, дуугүй суу, дүүгээ хар, хичээлээ давт” гэх мэтийн уцаарласан хариу биднээс байнга авдаг ч хөгжилтэй яриа, сахилгагүй зангаараа аав ээжийгээ хөгжөөн баясгаж байдаг бидний үрс шүү дээ.

Тэгвэл тэднийхээ бүтээлч сэтгэлгээг хамгаалж, хөгжүүлэхэд бид уцаарлаж биш ухааруулж, татгалзаж биш тайлбарлаж, хэрэв өөрсдөө хариулж мэдэхгүй бол хамтарч хэлэлцэн ярилцаж байх нь хамгаас чухал.

Сонирхолтой нь санаанд ч оромгүй сэтгэл зүйн таатай орчныг хүүхдүүд маань бүрдүүлж, сэтгээгүй тийм сонин оновчтой асуултыг тавьж, хариултыг хайж, томчууд бидний бүтээлч сэтгэлгээг бас хөгжүүлж өгдөг.

Ингээд, эндээс нэг гаргалгаа:

- ✓ хамгийн таатай орчин – Гэр бүл,
- ✓ хамгийн сайн баг – Гэр бүл,
- ✓ хамгийн амжилттай, аз жаргалтай суралцагчид – Гэр бүл.

Одоо хэдүүлээ хэрхэн хүүхдүүдийнхээ бүтээлч сэтгэлгээний хөгжилд аль болох тус нэмэр болох вэ? Энэ нь хүүхдүүдийн маань хөгжил хүмүүжилд сайнаас гадна аав ээжүүд, хүүхдүүдийн хоорондын жаргалтай, жинхэнэ найзуудын чин сэтгэлийн дотно харилцаанд тун чухал болох талаар ярилцая.

Жирийн нэгэн гэр бүлийн жирийн л нэг өдөр:

2. Хичээлээр хийгдэх ажлууд

- ✓ өглөө босоод гар нүүрээ угаав
- ✓ өглөөний цайндаа өндөгтэй боов шарж идэцгээв
- ✓ гадаа гарвал зөөлөн, дулаан бороо шивэрч байлаа
- ✓ хүүхдээ “сэтгэхүйн хөгжлийн хичээлд” нь хүргэж өгөөд, хүлээж байгаад авлаа
- ✓ буцах замдаа барилгачин ах эгч нар хэрхэн ажиллаж байгааг сонирхон хэсэг саатав
- ✓ тоглоомын талбай дээр хүүхэдтэйгээ бөмбөг тоглов
- ✓ оройн хоолондоо амттай банштай шөл чаналаа
- ✓ унтахын өмнө үлгэрээ уншив.

Хүүхэдтэйгээ хамт өнгөрүүлсэн энгийн нэгэн энэ өдөр ээж хүү хоёр (аав охин хоёр, эсвэл хүү охинтойгоо хоёулантай нь ч байж болно) лав л 8 ажил үйлс хийж, 8 өөр нөхцөл байдалд байсан байна.

Та нар юу гэж бодож байна, эдгээр 8-н хэд нь хүүхдийн сэтгэлгээ хөгжүүлэхэд чиглэсэн байж вэ?

Нэг – энэ бол хичээл,

Хоёр – хичээл ба тоглоом,

Гурав – хичээл, үлгэр, тоглоом гэх мэтээр үргэлжилсээр найм гэсэн хариулт ч байж болох юм.

Ашиглаж чадах юм бол эдгээр найман нөхцлийг бүгдийг нь хүүхдийнхээ сэтгэлгээний хөгжилд ашиглаж тэднийхээ мэдлэг, чадварыг дээшлүүлж, бас хүүхдүүдээсээ суралцаж болно, боломж бий. **Яаж?**

Яг одоо үзэцгээе!

1. Гар нүүрээ бас шүдээ угаалаа:



Жирийн л нэг айлын жирийн л нэг ванны өрөө. Сонирхол татсан, хариулт нэхсэн юу байна?

Ээж: Энд гар нүүрийн саван байна. Нэг нь цагаан нөгөө нь улаан юм.

Хүү: Ээж, өвөөгийнд ногоон, бас хар саван байна лээ.

Ээж: Тийм үү! Хар савангийн хөөс нь хар байх даа, ямар сонин юм бэ?

Хүү: Алив үзье. Цагааных цагаан, улааны хөөс ч гэсэн цагаан байна ээж ээ... гээд л хүүхэд шууд хариулт хайгаад, бүр туршилт шалгалт хийгээд эхэлнэ биз дээ?

Энэ дээр нь дараа дараагийн асуултуудаа алхам алхамаар тавих замаар өөрөөр нь хариултыг нь олуулаад, хариултаа шалгаж нотлоод баталгаатай мэдлэг болгоод авна даа. Ингээд ээж хүү хоёр Ялалт байгуулаад мэдлэгээ ахиулаад, танин мэдэхийн таашаал хоёюул эдлэх болно. Энэнээс их, илүү сонин зүйлсийг миний хүү том ангид ороод физик, химийн хичээлээсээ сурна даа гэхээр хүүхэд маань бүр урамшаад, хичээлээ сонирхоод эхэлнэ шүү дээ, тийм үү?

Та хариултыг шууд хэлээд өгч болно л доо. Ийм тохиолдол, заримдаа ингэх шаадлага ч зөндөө гарна. Шууд авсан хариулт хүүхдэд тийм ч “амттай” биш ой ухаанд нь ч гүн бат суудаггүй. Тиймээс боломж л байвал өөрөөр нь бодуул, арай барахгүй бол алхам алхамаар дөхүүлээд өг. Хүү чинь улам идэвхтэй сониуч, улам баяр хөөртэй үргэлжлүүлэх болно. Бяцхан суутнууд маань бүгдээрээ ийм л зан араншинтай улс юм шүү дээ.



Хүү: Ээж ээ, энэ ооны бөглөө нь ийм нарийн байхад, нөгөө нь ийм бүдүүн бөглөөтэй юм байна. Яагаад? Бас л нөгөө яагаад?

Ээж: Мм, тийм байна нээрээ. Ээж нь мэдэхгүй юм ааваас нь асууя.

Аав: Энэ их учиртай байх аа! За байз, дэлгүүрт ийм бүдүүн бөглөөтэйг нь хүмүүс илүү авадаг байх (маркетинг),

Ээж: Бүдүүн нь харахад хөөрхөн, онгойлгоход эвтэйхэн юм байна (дизайн, хэрэглээ)

Хүү: Нарийхныг зөвхөн хэвтүүлж тавина, бүдүүнийг бол босоогоор нь “зогсоож” болох нь...

гэх мэтээр гэр бүлийн Бүтээлч Сэтгэлгээ ажиллаж эхэлнэ, ЭТШ-ийн хайлтанд гарна гэсэн үг. Эндээс санаандгүй сонин шийдэл ч гарах нь цөөнгүй.

Ингээд цааш нь үргэлжлүүлэх юм бол 00-н суултуур бол тэр чигээрээ физикийн лаборатори гэсэн үг. Яагаад ус нь хэсэг хугацааны дараа тогтоод гоожихгүй байгаа юм, яагаад хоёр даруул байгаам, яавал бага ус хэрэглэх вэ? (гэр бүлийн санхүү, экологи), модон суултуур хуванцраас сайн уу? Гээд л үргэлжижлж өгнө.

2. Өглөөний цайнд өндөгтэй боов:



Өндөгтэй боовоо ээж нь хайруулын тавгандаа шарж байна. Харин шилэн тагны дотор тад нь усан дуслууд байхыг харсан хүү:

Хүү: Ээж, хаанаас усан дуслууд гараад ирэв ээ? Та ус хийгээгүй биз дээ?

Ээж: Харин чи юу гэж бодож байна? Би хийгээгүй.

Хүү: Аав ус хийчихсэн юм болов уу? ...

гэх мэтээр гэр бүлийн хэлэлцүүлэг болж эцэст нь бараг бүх юманд ус байдаг, тэр нь халуунд уур болон дээш дэгдээд хүйтэн тагны дотор талд усан дусал болон тогтдог гэсэн физикийн “нээлт” хийх нь ээ. Мэдээж бүр бага насныхандаа бол таарч тохирсон ойлголт, үгээр хариулж таарна.

Ном сурах бичиг, толь бичиг, Гүүгл ашиглаж болно, ааваасаа асууж мэднэ, бүр олж чадахгүй бол мэргэжлийн ахаасаа лавлана. Энэ бүгдийг хүүхдүүдтэйгээ хамт хийх нь л хамгийн чухал. Ингэснээр тэд маань мэдээлэл, мэдлэгийг хаанаас хайж, хэнээс авч болдог талаар зөндөө туршлагатай болно. Хүнээс юм асуухаасаа айхгүй, ичихгүй харилцаанд идэвхтэй оролцоно. Энэ бас чухал ач тус.

Хуу: Ээж, яагаад та өнөөдөр амтгүй боов хийчихсийн?

Ээж: Манай бор элсэн чихэр дууссан (аав ээжийн юм бас дуусдаг байх нь?), цагаан чихэр ээж нь хийгээгүй юм.

- Яагаад?

- Бор нь илүү эрүүл хүнс байгаа юм, хэдүүлээ удахгүй өвөөгийн д нь очно. Жинхэнэ цэвэр зөгийн бал өвөөд нь л байгаа даа.

- Дэлгүүрийнх тэгээд цэвэр биш, бохир юм уу? Зөгий хаанаас бал хураадаг юм бэ?



Гээд л явж өгнө дөө. Энд эрүүл мэнд, эрүүл хүнс, органик буюу ориг бүтээгдэхүүн г.м. хариултаудын хайгуулд гарна. Бид тэр болгон анзаардаггүй болохоос хамгийн чухал асуултуудыг хүүхдүүд минь л тавиад байгаа биз?

3. Гадаа шиврээ бороо орж байлаа



Гадаа зөөлөн ч гэсэн бороо орж байна. Хүүхдүүд маань гадаа гарч тоглохыг гуйлаа. Борооноор хүүхдүүд наадаж гүйх гойд дуртай шүү дээ. Бороонд норчихно оо, дараа больё дүүгийнх нь хоолой өвдвөл яана! гэвэл

- Бороонд норхоггүйн тулд ямар хувцас өмсөх вэ?

- Норсон юмны өнгө яагаад бараан болдог юм бол оо? Улаан малгай хүрэн болдог, цайвар саарал зам талбай бараан саарал болчихдог. Ус чинь өөрөө өнгөгүй шүү дээ, яагаад?

- Тэнгэрт байгаа бороо, цас доошоо газарт унаад байхад одод, нар сар яагаад унахгүй байна аа? Гээд л хөвөрч өгнө...

Энэ олон яагаадыг яагаад ч зүгээр өнгөрүүлж болохгүй. Харин ч хүүхдийн чинь яагаад цөөдөөд байвал энэ л асуудал дагуулна гэдгийг гойд анхаарч, болгоомжлох хэрэгтэй.. Тэгвэл дээрх маягаар бид өөрсдөө өдөөж, сонирхолыг нь төрүүлж өгч байх нь зүйтэй.



Замын шалбааг бидний уур уцаарыг төрүүлж, хот тохижуулахынхныг хараах хүсэл төрүүлдэг бол, харин манайхны хүүхдүүд тэр шалбааг дотроос алтан нар, хөвөн цагаан үүл, хөх мөнх тэнгэрийг олдог.

4. Сэтгэхүйн хичээл:



Хөгжүүлэх хичээл дээр хүүхдүүд маань хөтөлбөр программын дагуу олон сайхан дасгал, бүтээлүүд хийж сурдаг. Энэ сайн хэрэг, ялангуяа зав чөлөөгүй ажилтай улсад үүн шиг сайн юм хаа байхав. Ихэнх хүүхдүүд ийм хичээлд тун дуртай.

Гэхдээ хүүхэд бүр бүх талаараа адилгүй. Нэг нь хөгжимд, нөгөө нь зурагт, бас нэг нь бөмбөгт г.м. Багш хүүхэд бүртэй ажиллах боломжоор тааруу. Тэгэхээр аав ээжийн оролцоо зайлшгүй чухал байгаа биз?

Мөн хичээл бол хичээл. Хичээл бол хиймэл зохиомол хөтөлбөр шүү дээ. Тийм байхаас ч аргагүй. 25 хөөрхөн амьтсын 25 араншинд нийцсэн байна гэдэг юу л бол. Харин гэртээ, гадуур зугаалж явахдаа ч юм уу бид хүүхдүүдтэйгээ ёстой нөгөө “амьд харьцаа” буюу амьдрал дунд байж байдаг тул тэндээс олж авсан мэдлэг, ухаарал хамгийн өгөөжтэй нь. Иймээс л бид цэцэрлэг сургуулийн сургалтын зэрэгцээ энэ боломжийг их сайн ашиглаж баймаар байгаа юм даа.

5. Барилга дээр:

Буцах замдаа барьж байгаа барилгын хажуугаар явлаа. Барилгачид тод өнгийн “гоё” хувцастай байлаа.

Хүү: Яагаад бүгд цагаан малгайтай байгаа юм? Яагаад ийм тод гоё хантаазтай байгаа юм бэ?

Эндээс барилгын ажил бол хүнд хэцүү, их осолтой ажил. Осол гэмтлээс хамгаалах хэрэгтэй юу? Хэрэгтэй. Өндөр кранаас жолооч нь дороо байгаа хүнийг яаж сайн харах вэ г.м. олон асуулт хариулт үүснэ.



5. Бөмбөг тоглов:



Хэлбэр, хэмжээ, өнгө, материал нь бүгд ялгаатай байна. Яагаад?

Хамтарсан ярилцлага, хэлэлцүүлэг эхэлнэ дээ.

Аав, ээж, хүү, дүү бүгд өөрийнхөө санаагаа хэлнэ, сайн муу талаас нь шинжилнэ.

6. Оройн хоолон дээр банш чаналаа:



Оройн хоолонд ээж нь банш чаналаа.

Асуулт: Банш яагаад хөвөөд байна аа. Төмс, гоймон, мах бугд л хөвдөггүй шүү дээ. Амттай болгохын тулд чихэр хийж яагаад болохгүй гэж? ...

7. Үлгэр:



Үлгэр бол ерөөсөө хүүхдийн хөгжлийн эрдэнэсийн сан гэсэн үг.

Энэ талаар ямар асуултууд, ямар шийдлүүд байж болох вэ?
Энэ талаар ярилцаарай, саналаа ирүүлээрэй!

Сэдэвт ашигласан материал

1. Түдэв Л. Хүүхдээ цагт нь тодруулахуй / Лодонгийн Түдэв албан ёсны Facebook.- 2014.03.26.
 2. Монгол гэр бүл / Эмхт. Соёл урлаг судлалын хүрээлэн.- УБ.: Дэлхийн сонор хэвлэх үйлдвэр, 2017.- 184х.
 3. Үндэсний соёл- Гэр бүл / Эмхт. Соёл урлаг судлалын хүрээлэн.- УБ.: Дэлхийн сонор хэвлэх үйлдвэр, 2017.- 247х.
 4. Эрдэнэ- Очир Г. Хүнээр хүн хийх монгол ухааны сурвалж.- УБ.: Армийн хэвлэх үйлдвэр, 1991.- 175х.
 5. Эрдэнэ- Очир Г. Төрлийн хэлхээ.- УБ.: Сурах бичиг, хүүхдийн номын хэвлэлийн газар, 1993.- 72х.
- Цахим эх сурвалж:
1. <https://nafi.ru>

ДААЛГАВАР

1. **Та бүхэн өөрсдийн гэр бүлийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх үйл ажиллагаа, жишээ дасгалын загварыг гаргаж ярилцаарай.**
2. **Танай гэр бүлд ихэвчлэн хэлцэгддэг асуулт, хариул ямар байдгийг эрэгцүүлэн бодож, багачуудынхаа сонирхолтой, хөгжилтэй асуулт, хариулт, ярилцлагын сэдвээс хуваалцаарай.**